



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн орон нутгийн төсөв гүйцэтгэлээр нийт орлого 74,372.4 сая төгрөг бүрдүүлж 68,440.0 сая төгрөг зарцуулж 5,932.4 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан байна.

Аудитын код: БУА-2024/01-НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2023 он

Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга,

тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: 70342580

Аудитын менежер:

Утас: 70342716

Ахлах аудитор:

Утас: 70342716

Namchinsureng@audit.gov.mn

Цахим хаяг: Erdeneb@auditgov.mn

Ж.Энхцоодол

Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Г.Намчинсүрэн

Цахим хаяг:

АГУУЛГА:	
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товьёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
1.1.ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ.....	7
1.2.ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ.....	9
1.3.ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ	12
1.4.ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ.....	14
БҮЛЭГ 2. ТАТВАРЫН ЗАРЛАГА	17
БҮЛЭГ 3. ХУДАЛДАН АВСАН БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ	18
БҮЛЭГ 4. ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ ХҮРСЭН ҮР ДҮН	23
БҮЛЭГ 5. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	24
БҮЛЭГ 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ	25
БҮЛЭГ 7: ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	28
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	28
Хавсралтууд	31



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/09

Булган сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг аймгийн Засаг дарга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргад тус тус хүргүүлэхийг аудитын менежер (Ж.Энхцоодол)-д үүрэг болгосугай.

3.Аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Б.Ариун-Эрдэнэ), аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт) нарт зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (Г.Намчинсүрэн), (П.Мөнхтуяа), аудитын менежер (Ж.Энхцоодол) нарт тус тус даалгасугай.

5.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Булган аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Г.Намчинсүрэн), (П.Мөнхтуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ



Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УИХ	Улсын Их Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТҮА	Тохижилт үйлчилгээний анги
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ААНБОАТ	Аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар

Хүснэгтийн товьёг

Хүснэгт 1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт	7
Хүснэгт 2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл	9
Хүснэгт 3 Орон нутгийн төсвийн орлогын биелэлтийг аймаг, сумын дүнгээр авч үзвэл	10
Хүснэгт 4 Орон нутгийн зардлын төлөвлөлт	13
Хүснэгт 5 Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	14
Хүснэгт 6 Худалдан авсан бараа ажил үйлчилгээний гүйцэтгэл	18
Хүснэгт 7 Нэмэлт санхүүжилтийн орлогын судалгаа	24
Хүснэгт 8 Дамжуулан зээлдүүлэх гэрээ	25
Хүснэгт 9 Төсөвт байгууллагын зөрчлийн ангидал	27

Дүрслэл № 1 Орон нутгийн төсвийн орлогыг нэмж, бууруулж баталсан орлогын нэр төрөл	8
Дүрслэл № 2 Орон нутгийн зардлын төлөвлөлт	14
Дүрслэл № 3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлүүд хуулийн заалтаар	17
Дүрслэл № 4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийн шийдвэрлэлт	17

Хавсралт № 1	31
Хавсралт № 2	33
Хавсралт № 3	34
Хавсралт № 4	37
Хавсралт № 5	41
Хавсралт № 6	51
Хавсралт № 7	53
Хавсралт № 8	61
Хавсралт № 9	69

**Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/11 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын сэдэв батлах тухай”, А/12 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Булган аймгийн 2023 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

**Аудитын
зорилт**

- Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, түүний танилцуулга /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/
- Татварын зарлагын судалгаа /иргэдэд олгосон ХХОАТ-ын хөнгөлөлт/
- 2023 оны худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл.
- Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүн /Хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, түүний үр дүн нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан шалтгаан/

**Аудитын
хамарсан
хүрээ**

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Сангийн яамнаас Булган аймгийн 2023 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

**Аудитын арга
зүй**

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

“Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторын А/106 тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж”ийг баримтлан болгон аймаг, сумдын ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтэс, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- Төсвийн тухай хууль
- Аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрээр баталсан төсөв
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тогтоол
- Өрийн удирдлагын тухай хууль
- Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд,
- Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор А.Сувдаа нар 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл

Байхгүй.

БҮЛЭГ 1. ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

1.1.ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

1.1.1 Орон нутгийн төсвийн орлогыг УИХ-аас баталсан суурь орлогоос орлогын нийт дүнгээр нэмэгдүүлсэн боловч зарим нэр төрлийн орлогыг бууруулж баталсан байна.

Булган аймаг 2023 оны төсвийн төслийн саналд орон нутгийн суурь орлогыг 26,364.6 сая төгрөгөөр тооцож Сангийн яаманд хүргүүлснийг Сангийн яам 27,767.9 сая төгрөгөөр буюу 1,403.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж хянасан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харах/

УИХ-ын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай” хуулиар орон нутгийн суурь орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 2,065.5 сая төгрөгөөр өсгөж баталсан байна. / Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харах /

Булган аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Булган аймгийн 2023 оны төсөв батлах” XII/21 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Сумын 2023 оны төсөв” батлах тогтоолуудаар орон нутгийн төсвийн нийт орлогыг 51,632.4 сая төгрөгөөр төлөвлөжээ.

УИХ-ын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж Булган аймгийн суурь орлогыг 29,833.3, суурь зарлагыг 40,756.2 сая төгрөгөөр орон нутгийн төсөвт өгөх дэмжлэгийг 10,922.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж өөрчилсөн байна.

Дээр дурдсан өөрчлөлтэй холбоотойгоор Булган аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Булган аймгийн 2023 оны төсөв батлах” XII/01 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Сумын 2023 оны төсөв батлах тухай” тогтоолоор орон нутгийн төсвийн нийт орлогыг 74,778.0 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Дээрх тогтоолоор сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,723.8 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр орлогыг аймгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Энэ нь өмнөх оны төлөвлөлтөөс 62.3 хувь буюу 28,774.2 сая төгрөгөөр орон нутгийн орлогын төлөвлөгөө өссөн байна.

Хүснэгт 1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт

/сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он төлөвлөлт	Төсвийн төсөлд өгсөн санал	2023 он				Зөрүү
			Сангийн яамнаас хянасан	УИХ анх баталсан	ИТХ 2022.12.0	ИТХ 2023.08.0	
1	2	3	4	5	6	7	8
Нийт орлого ба тусламжийн дун	46,003.8	26,364.7	27,767.9	29,833.4	51,632.4	74,778.0	28,774.2
Татварын орлого	29,170.2	25,221.7	26,622.9	26,260.4	29,082.0	46,166.9	16,996.7
Татварын бус орлого	16,833.6	1,143.0	1,145.0	3,573.0	22,550.3	28,611.1	11,777.5

УИХ-аас батлагдсан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор орон нутгийн орлогын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

Татварын орлогын төлөвлөгөөнд 13 нэр төрлийн орлогыг 20,010.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1 нэр төрлийн орлогыг 5.3 сая төгрөгөөр бууруулж, татварын бус орлогын төлөвлөгөөнд 3 нэр төрлийн орлогыг 235.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Дүрслэл № 1 Орон нутгийн төсвийн орлогыг нэмж, бууруулж баталсан орлогын нэр төрөл



Нэмж баталсан татварын орлогын нэр төрөл:

- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөрийн орлого-1,928.7 сая төгрөг
- Үйл ажиллагааны орлого-3.3 сая төгрөг
- Хөрөнгийн орлого-14.0 сая төгрөг
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар-1,976.6 сая төгрөг
- Бууны албан татвар-0.04 сая төгрөг
- Малын хөлийн албан татвар-1,722.6 сая төгрөг
- Улсын тэмдэгтийн хураамж-1.0 сая төгрөг
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр-35.5 сая төгрөг
- Хог хаягдлын хураамж-82.8 сая төгрөг
- Газрын төлбөр – 545.6 сая төгрөг
- Дуудлага худалдааны орлого-210.0 сая төгрөг
- Ойн нөөц ашигласны төлбөр-1.6 сая төгрөг
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр-13,489.0 сая төгрөг

Төсвийн орлогыг нэмэгдүүлэн баталсан шалтгаан тайлбарыг тодруулбал:

- Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого, үйл ажиллагааны орлого нь Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор цалингаас суутгах ХХОАТ өссөн;

- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг Сангийн яамнаас ирүүлсэн удирдамж, ТАБ-аас гүйцэтгэсэн аудитын дүнд татвар ногдоогүй үл хөдлөх хөрөнгийн албан татвар 319.2 сая төгрөгийг нөхөж ногдуулсантай холбоотойгоор орлого давж биелсэн;
- Газрын төлбөрийг аймгийн Татварын хэлтсийн ирүүлсэн өрийн үлдэгдэлд үндэслэсэн;
- Дуудлага худалдааны орлогыг хагас жилийн байдлаарх гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн;
- Хог хаягдлын хураамж, малд ногдуулах албан татварыг ТАБ-аас 80 хувиар тооцон 115.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал, зөвлөмжийн дагуу нэмэгдүүлэн төлөвлөсөн;
- Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг тооцох итгэлцүүрт Засгийн газрын 2022 оны 416 тоот тогтоолоор өөрчлөлт орсноор төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоолол нэмэгдсэн бөгөөд үүнийг Сангийн яам төсвийн төслийг хянахдаа хуучин тооцооллоор тооцож төсвийг хянасан тул усны ашигласны төлбөрийн орлого давж биелсэн;
- Татварын шууд бус орлогыг УИХ-аас баталсан суурь орлогын дүнгээс 5.3 сая төгрөгөөр бууруулан баталсан нь Сангийн яам суурь орлогын төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслээгүй шууд 60.0 сая төгрөгийн орлогыг төсвийн санал дээр нэмэгдүүлэн хянасантай холбоотойгоор суурь орлогын нийт дүнг бураагүй тул тухайн орлогын төлөвлөгөөг бууруулсан байна;

2022 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх талаар 5 нэр төрлийн татварын орлогыг 547.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал хүргүүлснийг Санхүү төрийн сангийн хэлтэс хүлээн авч төсвийн төсөлд тусгасан нь нөлөөлсөн байна.

1.2.ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

1.2.1 Орон нутгийн төсвийн орлого нийт дүнгээрээ 74,372.4 сая төгрөг буюу 1 хувиар давж биелсэн боловч зарим нэр төрлийн татварын орлого болон татварын бус орлого тасарсан байна.

Орон нутгийн төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс татварын орлого 7.5 хувиар давж биелсэн, татварын бус орлого 10.5 хувиар тасарсан байна. /дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу/

Хүснэгт 2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл

/сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2023 он		Өмнөх оноос	
				Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	49,143.3	73,821.7	74,372.4	550.7	0.01	25,229.2	0.51
ТАТВАРЫН ОРЛОГО	32,827.2	46,166.9	49,620.1	3,453.2	0.07	16,792.9	0.51
Орлогын албан татвар	8,125.8	9,104.7	10,683.2	1,578.5	0.17	2,557.4	0.31
Хувь хүний орлогын албан татвар	8,035.1	9,354.7	10,662.5	1,307.8	0.14	2,627.5	0.33
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(471.2)	(700.0)	(611.8)	88.2	(0.13)	(140.6)	0.30
ААН-ын орлогын албан татвар	561.9	450.0	632.5	182.5	0.41	70.6	0.13
Хөрөнгийн албан татвар	3,175.0	5,828.1	5,368.7	(459.4)	(0.08)	2,193.7	0.69

Булган аймгийн ТЕЗ-ийн 2023 оны нээгдсэн төсвийн гүйцэтгэл

Бусад татвар, төлбөр, хураамж	21,526.4	31,234.1	33,568.2	2,334.1	0.07	12,041.8	0.56
Бусад нийтлэг төлбөр, хураамж	483.8	549.4	539.3	(10.0)	(0.02)	55.6	0.11
Газрын төлбөр	1,612.0	2,055.3	2,158.6	103.3	0.05	546.6	0.34
Байгалийн нөөц ашигласны төлбөр	19,303.7	28,549.4	30,733.1	2,183.8	0.08	11,429.5	0.59
Бусад татвар	127.0	80.0	137.1	57.1	0.71	10.1	0.08
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,316.0	27,654.8	24,752.4	(2,902.4)	(0.10)	8,436.3	0.52
Нийтлэг татварын бус орлого	4,283.1	7,312.9	4,723.9	(2,589.1)	(0.35)	440.8	0.10
Хөрөнгийн орлого	225.4	50.0	54.0	4.0	0.08	(171.3)	(0.76)
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	11,807.6	20,291.8	19,974.4	(317.4)	(0.02)	8,166.8	0.69
ТӨСВИЙН ОРЛОГО	34,871.7	51,044.7	51,938.7	894.0	0.02	17,067.0	0.49

Орон нутгийн нийт татварын орлогын төлөвлөгөө даван биелэхэд ХХАОТ-ын орлого 1,307.7 сая төгрөг, ААНОАТ-ын орлого 182.5 сая төгрөг, бусад төлбөр хураамжийн орлого 2,334.1 сая төгрөг, газрын төлбөрийн орлого 103.2 сая төгрөгөөр тус тус давж биелсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөөгүй биелээгүйд нийтлэг бус татварын орлого 2,589.0 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,132.8 сая төгрөгөөр биелээгүй, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 317.0 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 3 Орон нутгийн төсвийн орлогын биелэлтийг аймаг, сумын дүнгээр авч үзвэл /сая.төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2023 он		Өмнөх оноос	
					Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	49,143.27	73,821.69	74,372.43	550.74	0.01	25,229.17	0.51
11	ТАТВАРЫН ОРЛОГО	32,827.22	46,166.90	49,620.08	3,453.18	0.07	16,792.86	0.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,316.04	27,654.79	24,752.35	(2,902.44)	-0.10	8,436.31	0.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	-	-	-	-	-	-
14	ТӨСВИЙН ОРЛОГО	34,871.71	51,044.72	51,938.74	894.02	0.02	17,067.02	0.49
Аймаг:								
1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	30,499.57	47,981.77	48,227.00	245.23	0.01	17,727.43	0.58
11	ТАТВАРЫН ОРЛОГО	20,509.36	28.74	31,840.49	31,811.75	1106.86	11,331.13	0.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,990.21	19,241.27	16,386.51	(2,854.76)	-0.15	6,396.30	0.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	-	-	-	-	-	-
14	ТӨСВИЙН ОРЛОГО	21,488.87	31,512.74	32,803.87	1,291.14	0.04	11,315.00	0.53
Сумд:								
1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	18,643.69	25,839.92	26,145.43	305.52	0.01	7,501.74	0.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	12,317.86	46,138.16	17,779.59	(28,358.57)	-0.61	5,461.73	0.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,325.83	8,413.52	8,365.84	(47.68)	-0.01	2,040.01	0.32
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	-	-	-	-	-	-
14	ТӨСВИЙН ОРЛОГО	13,382.85	19,531.98	19,134.87	(397.12)	-0.02	5,752.02	0.43

Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 47,981.8 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 48,227.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөө 245.2 сая төгрөг буюу 0.5 хувиар давж биелсэн нь Засгийн газрын цалин нэмэгдүүлэх, орон нутгийн

нэмэгдэл олгох зэрэг тогтоолуудын дагуу цалин нэмэгдэж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос суутгах ХХОАТ-ын орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Сумдын төсвийн орлого 25,839.9 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 26,145.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөө 305.5 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар давж биелсэн байна.

Тайлант онд төлөвлөсөн төсвийн орлого нийт дүнгээрээ биелсэн ч нэр төрлөөрөө зарим орлогын төлөвлөгөө тасарсан байна. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн орлогын албан татварын орлого 130.1 сая төгрөгөөр тасарсан нь татварыг урьдчилан төлөвлөх боломжгүй тул өмнөх оны гүйцэтгэлийн түвшинд үндэслэн төлөвлөдөг,
- Малд ногдуулах албан татварыг Могод, Тэшиг, Хангал, Булган сум нийт 9.6 сая төгрөгөөр төлөвлөгөөг давж биелүүлсэн бол 13 сум нийт дүнгээр 440.0 сая төгрөгөөр тасарсан нь малчин болон мал бүхий иргэдэд үүсгэх нэхэмжлэх малын тоо толгойн нэгдсэн сангийн мэдээллээс шалтгаалан хугацааны хувьд харьцангуй оройтож үүсдэг, малын тоо толгойн албан татварыг 100 хувь төлөвлөсөн,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 7 сум 0.1-5.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бол 10 сум нийт дүнгээр 33.8 сая төгрөгөөр тасарсны 67 хувь буюу 22.8 сая төгрөгөөр Дашинчилэн сум эзэлж байгаа нь төсвийн орлогыг биелүүлэх идэвх санаачилгагүй ажилласан, мөн тухайн суманд татварын байцаагчийн орон тоо дутуу байсантай холбоотой байна,
- Газрын төлбөр 273.9 сая төгрөгөөр тасарсан нь иргэд, аж ахуй нэгж байгууллагууд газрын төлбөрөө төсөвт бүрэн төлөөгүй, холбогдох мэргэжилтнүүд арга хэмжээ авч ажиллаагүй ч газрын дуудлага худалдааны орлого 377.2 сая төгрөгөөр давсан,
- Ойн нөөц ашигласны төлбөрийг 12 сум бүрдүүлэхээс Тэшиг сум 8.8 сая төгрөг, Булган сум 0.6 сая төгрөгөөр давуулсан бөгөөд 10 сум 1.7-32.5 сая төгрөг нийт дүнгээр 85.5 сая төгрөгөөр тасарсан нь ойн нөөцийг тодорхойлох боломжгүй нь нөлөөлсөн байна.

Сумын татварын орлогоос аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,723.8 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 1,723.8 сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ-ийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар сумын ИТХ-аар батлуулсан төсөвт төвлөрүүлэх орлогыг дутуу төвлөрүүлсэн. Тухайлбал:

- Орхон сумын ХХОАТ, хөрөнгийн орлого, улсын тэмдэгтийн хураамжийн орлого төлөвлөгөөнөөс давсан ба бусад орлого 12.8-71.7 хувиар буюу нийт 153.3 сая төгрөгөөр тасарсан,
- Дашинчилэн сум татварын болон татварын бус орлогыг бодитой төлөвлөөгүй, 11 нэр төрлийн 142.5 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан,

- Хутаг-Өндөр сум татварын болон татварын бус орлогыг бодитой төлөвлөөгүй, 6 нэр төрлийн 70.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг дутуу төвлөрүүлсэн байна.
- Сайхан сумын татварын орлого нийт дүнгээрээ 93.8 хувиар биелэлттэй 27.5 сая төгрөгөөр тасалсан, үүнээс 4 төрлийн орлого 29.9 сая төгрөгөөр давж, 13 нэр төрлийн татварын орлогоос 8 төрлийн орлогыг 55.5 сая төгрөгөөр тасарсан,
- Гурванбулаг сумын үйл ажиллагааны орлого, шууд бус орлого, газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар, малд ногдуулах албан татвар нийт дүнгээр 33.9 сая төгрөгөөр тасарсан,
- Баян-Агт сумын татварын орлого нийт дүнгээрээ 105.6 хувиар биелсэн боловч үйл ажиллагааны орлого 21.9 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар 68.8 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 8.7 сая төгрөгөөр тус тус тасалсан,
- Хангал сумын ЗДТГ 3.5 сая төгрөг, ИТХ 0.01 сая төгрөгийн газрын төлбөрийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн,
- Хишиг-Өндөр сум орлогын төлөвлөгөөг батлахдаа газрын төлбөрийн өмнөх оны үлдэгдэл 2.2 сая төгрөг, галт зэвсгийн албан татварын өрийн үлдэгдэл 1.1 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 2.3 сая төгрөг нийт 5.6 сая төгрөгийг нэмж төлөвлөөгүй,
- Баяннуур сум орлогын төлөвлөгөөг батлахдаа газрын төлбөрийн өмнөх оны үлдэгдэл 1.3 сая төгрөг, галт зэвсгийн албан татварын өрийн үлдэгдэл 0.6 сая төгрөг нийт 1.9 сая төгрөгийн нэмж төлөвлөөгүй,
- Бугат сумын ЗДТГ-ын өөрийн үйл ажиллагааны 0.7 сая төгрөгийн түрээсийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн,

Иймд цаашид аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагч нар орон нутгийн төсвийн орлогыг төлөвлөхдөө орлогыг бааз, суурь судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан төлөвлөх, төлөвлөж батлуулсан орлогыг нэр төрөл бүрээр төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах, санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

1.3.ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

1.3.1. Орон нутгийн нийт зарлагыг УИХ-аар баталсан урсгал зарлагыг 22,715.5 сая төгрөгөөр нэмж баталжээ.

Аймгийн ТЕЗ 2023 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг нийт 46,762.7 сая төгрөгөөр төслийг боловсруулж Төсвийн тухай хуулийн 8.4.3 дахь заалтын дагуу Сангийн яаманд хүргүүлснийг Сангийн яам 18.7 сая төгрөгөөр буюу 40 хувиар бууруулан 28,030.9 сая төгрөгөөр хянажээ. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу/

УИХ-ын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай” хуулиар орон нутгийн суурь зарлагыг Сангийн яамны хянасан дүнгээс 8.7 сая төгрөгөөр өсгөж баталсан байна.

Булган аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Булган аймгийн 2023 оны төсөв батлах” XII/21 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Сумын 2023 оны төсөв батлах тухай” тогтоолуудаар орон нутгийн төсвийн зарлагыг УИХ-ын баталсан дүнгээс 35.2 сая төгрөгөөр өсгөж 72.087.8 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

УИХ-ын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж Булган аймгийн суурь зарлагыг 40,756.2 сая төгрөгөөр орон нутгийн төсөвт өгөх дэмжлэгийг 10,922.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж өөрчилсөн байна.

Дээрх өөрчлөлтэй холбоотойгоор Булган аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Булган аймгийн 2023 оны төсөв батлах тухай” XII/01 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Сумын 2023 оны төсөв батлах тухай” тогтоолуудаар орон нутгийн төсвийн зарлагыг өмнөх дүнгээс 22,273.5 сая төгрөг буюу 29.8 хувиар нэмэгдүүлж 94,361.3 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Төсвийн зарлагын төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулахад 39,700.2 сая төгрөгөөр буюу 72.7 хувиар өссөн байна.


Хүснэгт 4 Орон нутгийн зардлын төлөвлөлт

/сая төгрөг/

№	Эдийн засгийн ангилал/ Байгууллагын нэр	Өмнөх оны төлөвлөл т	Төсвийн н төсөл	СЯ хянаса н	УИХ баталса н	ИТХ 2022.12. 03	ИТХ 2023.08. 04	Зөрүү
А	Б	1	2	3	4	5	6	7
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	54,661.1	46,762.7	28,031.0	40,756.3	72,087.8	94,361.3	39,700.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,874.7	45,732.5	28,031.0	39,318.2	48,631.1	62,033.7	27,159.0
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,452.1	44,215.1	27,673.8	35,973.2	35,789.1	46,221.3	12,769.2
211	Хүү	-	-	-	2,389.0	-	-	-
212	ТАТААС	425.2	667.7	11.3	376.2	399.9	399.9	(25.3)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	997.4	849.8	345.9	579.7	12,442.1	15,412.5	14,415.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,110.0	1,030.2	-	1,438.1	18,332.7	25,995.6	9,885.6
	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,676.4	-	-	-	5,124.1	6,332.1	2,655.7
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	54,661.1	46,762.7	28,031.0	40,756.3	72,087.8	94,361.3	39,700.2
31	Улсын төсвөөс санхүүжих		45,864.5	28,023.0	40,717.3	-	-	-
32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,247.4	873.2	-	-	59,380.2	84,147.0	41,899.6
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	12,413.6	25.0	8.00	39.00	12,707.6	10,214.3	(2,199.3)

Эх сурвалж: төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл.

Дүрслэл № 2 Орон нутгийн зардлын төлөвлөлт



1.4.ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

1.4.1. Урсгал зардлыг 14.6 хувиар буюу 12,003.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна

Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XIV/01 дүгээр тогтоолоор болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолуудаар 2023 оны төсвийн нийт зарлагыг 82,167.7 сая төгрөгөөр баталж 68,440.0 сая төгрөг буюу 83.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь аймгийн урсгал зардал 946.0 сая төгрөг, хөрөнгийн зардал 1,730.3 сая төгрөг, сумын урсгал зардал 1,756.5 сая төгрөг, хөрөнгийн зардал 3,480.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 5 Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн

/сая.төгрөг/

Код	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2023 он		Өмнөх оноос	
					Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,639.8	82,167.7	68,440.0	13,727.7	83.3	22,800.2	50.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,556.4	49,840.1	45,412.9	4,427.2	91.1	12,856.5	29.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,200.7	46,214.2	43,056.9	3,157.3	93.2	11,856.2	38.0
211	ХҮҮ	56.0	-	721.6	(721.6)		665.5	1,188.2
212	ТАТААС	366.2	399.9	361.3	38.7	90.3	(4.9)	(1.3)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	933.5	3,226.0	1,273.2	1,952.8	39.5	339.7	36.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,373.5	25,995.6	20,808.2	5,187.4	80.0	9,434.7	83.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,710.0	6,332.1	2,218.9	4,113.2	35.0	509.0	29.8
АЙМАГ:								
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,666.8	38,808.0	33,151.0	5,657.1	85.4	14,484.2	77.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,124.2	19,760.7	18,814.0	946.7	95.2	6,689.8	55.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,261.1	18,206.4	16,781.4	1,425.0	92.2	5,520.2	49.0
211	ХҮҮ	56.0	-	721.6	(721.6)		665.5	1,188.2
212	ТАТААС	366.2	399.9	361.3	38.7	90.3	(4.9)	(1.3)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	440.9	1,154.4	949.8	204.6	82.3	508.9	115.4

Булган аймгийн ТЕЗ-ийн 2023 оны нээгдсэн төсвийн гүйцэтгэл

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,532.6	15,784.1	14,053.8	1,730.3	89.0	7,521.2	115.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	10.0	3263.3	283.2	2,980.1	8.7	273.2	2,731.7
СУМД:								
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,973.0	43,359.7	35,289.1	8,070.7	81.4	8,316.0	30.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,432.2	30,079.4	26,599.0	3,480.4	88.4	6,166.7	30.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,939.6	28,007.8	26,275.5	1,732.3	93.8	6,335.9	31.8
211	ХҮҮ	-	-	-	-	-	-	-
212	ТАТААС	-	-	-	-	-	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	492.6	2,071.6	323.4	1,748.1	15.6	(169.2)	(34.3)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,840.8	10,211.5	6,754.4	3,457.2	66.1	1,913.5	39.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,700.0	3,068.8	1,935.7	1,133.1	63.1	235.8	13.9

Орон нутгийн нэгтгэсэн төсвийн зарлагын дүнд ТЕЗ-ийн нийт зарлагын дүн 33,150.0 сая төгрөг буюу 48.5 хувь, ТТЗ-ийн нийт зарлагын дүн 35,289.1 сая төгрөг буюу 51.5 хувийг тус тус эзэлж байна.

Хөрөнгийн зардал өмнөх оноос 9,434.7 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 509.0 сая төгрөгөөр, урсгал зардал 12,856.2 сая төгрөгөөр тус тус өсөж, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 50.0 хувиар өссөн байна. /Дэлгэрэнгүй судалгааг хавсралт 4-өөс харна уу /

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх болон урсгал зардалтай холбоотой зарим зардлын өсөлт нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Цалин хөлс 4,454.6 сая төгрөг буюу 52.4 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 543.4 сая төгрөг буюу 51.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн секторын албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхүй хэмжээний өөрчлөлт орсон,
- Байр ашиглахтай холбоотой зардал 20.0 сая төгрөг буюу 160 хувиар нэмэгдсэн нь Булган сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилга шинээр баригдаж байгаатай холбогдуулан тухайн цэцэрлэгийн 2022 оны үйл ажиллагаа явуулах байрны түрээсийн зардлын гэрээний үлдэгдэл дүнг санхүүжүүлэхээр 20.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 83.1 хувь буюу 27.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, хоол хүнсний зардал 7.9 сая төгрөг буюу 50.9 хувиар нэмэгдсэн нь сумдын төсөвт тодотгол хийсэн,
- Тавилга хэрэгслийн зардал 58.4 сая буюу 57.9 хувиар нэмэгдсэн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 1,523.7 сая төгрөг буюу 205.8 хувиар нэмэгдсэн, бараа үйлчилгээний бусад зардал 3,394.9 сая төгрөг буюу 43.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн ус, рашаан ашигласны төлбөрийн орлого даван биелсэнтэй холбоотойгоор нийт зарлагыг нэмэгдүүлсэн,

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн гадаад томилолтын судалгаа				
№	Байгууллагын нэр	хүний тоо	төлөвлөгөө	/сая.төгрөг/ гүйцэтгэл
1	БОАЖГ	1	5.5	5.5
2	Аймгийн ЗДТГ	16	80.5	47.3
3	Аймгийн ИТХ	18	85.0	43.0
4	ОНӨГ	1	35.0	3.5
5	СХАА	1	2.1	2.1
6	Хангал ЗДТГ	1	8.3	8.3
	Нийт	38	216.4	109.5

Аудитын илрүүлэлт: Тухайлбал

- Аймгийн ЗДТГ-ын гадаад томилолтын зардалд нийт 216.4 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 109.6 сая төгрөгийг зарцуулж гүйцэтгэл 50.6 хувьтай байхад ТЕЗ нь Бүгд найрамдах Солонгос ард улс руу аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 25.5 сая төгрөгийн сургалтын зардалд зарцуулж анхан шатны баримт болон зарцуулалтын тайлан мэдээг бүрдүүлж ажиллаагүй байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн тэнцэл.

Орон нутгийн 2023 оны төсвийн нийт орлогыг 74,778.0 сая төгрөгөөр , төсвийн зарлагыг 94,361.3 сая төгрөг нийт тэнцэл 19,583.3 сая төгрөгийн зөрүүг санхүүжүүлэх эх үүсвэрийг ОНХНС-гаас санхүүжих 9,368.9 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос 3,592.3 сая төгрөг, оны үлдэгдлээс 6,622.1 сая төгрөг тус тус бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн нийт орлого 74,372.4 сая төгрөг бүрдүүлж, 68,440.0 сая төгрөг зарцуулж 5,932.4 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан байна.

1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

1.4.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос 45.8 хувиар буурсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор “Төрийн хэмнэлтийн тухай” хууль, “Алсын хараа-2050” урт хугацааны бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын үзэл баримтлалд нийцүүлж аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн зарим зорилт, арга хэмжээнд өөрчлөлт оруулахаар тооцоо судалгааг хийж ажиллаж үүрэг чиглэлээр ханган ажилласан ч зарим орон нутгийн төсөвт байгууллагууд төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Аудитаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 58.9 сая төгрөгийн 20 зөрчил илрүүлснээс 8.7 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт, 45.7 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 4.4 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлжээ. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1.4, 12 дугаар зүйлийн 1.3, 3.1, 15 дугаар зүйлийн 1.5 дахь заалтуудыг тус тус зөрчиж бэлэг дурсгалын зүйл, хандив сонин хэвлэл худалдан авч олгосон байна. /Могод сумын ЗДТГ, Бугат сумын ИТХ, Бугат сумын ЗДТГ, Хангал сумын ЗДТГ, Хялганат тосгоны захирагчийн ажлын алба, Орхон сумын ЗДТГ, Орхон сумын ИТХ-8.7 сая төгрөг/
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2.3, 14 дүгээр зүйлийн 4, 6 дугаар зүйлийн 4 дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй. /Бугат сумын ЗДТГ, Хангал сумын ЗДТГ, “Илчит хутаг” ОНӨААТҮГ, СХДАА, Бугат сумын ИТХ,

Дүрслэл № 3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлүүд хуулийн заалтаар

Дүрслэл № 3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийн шийдвэрлэлт



БҮЛЭГ 2. ТАТВАРЫН ЗАРЛАГА

2.1. Нийт 756 татвар төлөгчдөд 611.8 сая төгрөгийн татварын буцаан олголтыг олгосон байна.

Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйл, 2006 онд баталсан баталсан ХХОАТ-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12, шинэчилсэн найруулсан ХХОАТ-ын тухай хуулийн 23 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тушаалаар батлагдсан “Илүү төлсөн албан татварыг буцаан олгох, хяналт тавих, нягтлан бодох бүртгэлд тусгах журам”-ын 2.7 дахь хэсэгт заасны дагуу нийт 756 татвар төлөгчдөд 611.8 сая төгрөгийн татварын буцаан олголтыг олгосон байна.

БҮЛЭГ 3. ХУДАЛДАН АВСАН БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

3.1. Төлөвлөсөн төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүйгээс хөрөнгийн зардал 68.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна

Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн болох худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3-д заасны дагуу тайлагнасан байна. Үүнд:

Хүснэгт 6 Худалдан авсан бараа ажил үйлчилгээний гүйцэтгэл

/сая.төгрөг/

Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр	Худалдан авахаар төлөвлөсөн бараа, ажил үйлчилгээний тоо	Батлагдсан төсөв	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээ	Санхүүжилт	Санхүүжилтийн хувь
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	47	6,185.8	45	5,308.9	85.8
Их засвар	25	3,874.6	23	3,457.1	89.2
Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	21	4,600.9	20	3,882.4	84.4
Байгаль хамгаалах сан	54	6,977.2	51	5,849.4	83.8
Аймгийн авто замын сан	11	1,200.0	8	761.2	63.4
Нийт дүн	158	22,838.5	147	19,259.0	81.3

Эх сурвалж: төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид тайлант оны худалдан авсан бараа, ажил үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт зааснаар төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнан ажилласан байна.

Доор дурдах хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний тоо төсөвт өртөгт хэмжээг өөрчлөлт нь ус рашаан ашигласны төлбөрийн орлого даван биелсэнтэй холбогдуулан УИХ-аас баталсан суурь зарлагыг нэмэгдүүлэн төсвийн тодотголоор тухай бүр өөрчлөн баталсан байна.

3.1.Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэл:

Тайлант онд нийт нийт 3,553.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй байгууламж, тоног төхөөрөмж, их засварын 33 төсөл, арга хэмжээнээс 2023 онд 3,103.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдаж тайлант онд 30 төсөл арга хэмжээнд 2,433.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. /Хавсралт 5-аас харна уу/

Тайлант онд аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх баталсан төсөл арга хэмжээнд дараах өөрчлөлтүүд орсон байна.Үүнд:

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтад:

1. Аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн XIV/01 дүгээр хуралдаанаар тайлант онд шинээр хэрэгжих 2 төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 370.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, шинээр нэмж 23 төсөл арга хэмжээнд 1,143.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.
2. Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XIV/01 дүгээр тогтоолоор 2 төсөл арга хэмжээний тайлант онд санхүүжүүлэх дүнг 45.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, шинээр 5 төсөл арга хэмжээнд 348.0 сая төгрөгийг зарцуулахаар тус тус өөрчилж баталсан байна.

Аймгийн их засварын хөрөнгө, оруулалтад:

1. Аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн XIV/01 дүгээр хуралдаанаар тайлант онд шинээр хэрэгжих 2 төсөл арга хэмжээний тайлант онд санхүүжих дүнг 380.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, шинээр нэмж 9 төсөл арга хэмжээнд 818.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.
2. Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XIV/01 дүгээр тогтоолоор 20.0 сая төгрөгийн өртөгтэй 1 төсөл арга хэмжээг хасаж 3 төсөл арга хэмжээний тайлант онд санхүүжүүлэх дүнг 52.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, шинээр 3 төсөл арга хэмжээнд 242.5 сая төгрөгийг зарцуулахаар тус тус өөрчилж баталсан байна.

ТЕЗ-ийн 2023 онд Төрийн аудитын газраас өгсөн 3 төсөл арга хэмжээний 210.0 сая төгрөгийн саналыг төсвийн төсөлд тусгасан байна.

3.1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл хөтөлбөрийг хөгжлийн бодлогын зорилтын арга хэмжээтэй уялдуулж төлөвлөөгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн төлөвлөхөөр 2015-2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, 2020 оноос Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн дунд хугацааны баримт бичгүүд буюу Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй нийцээгүй 580.0 сая төгрөгийн 7, аймгийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцээгүй 3,172.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл арга хэмжээ нийцээгүй байна. Энэ нь орон нутгийн төсөл арга хэмжээний 43 хувийг эзэлж байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 6-аас харна уу/

Дээрхээс дүгнэхэд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг хөгжлийн зорилтыг хангах зорилгоор төлөвлөж байгаа эсэх нь учир дутагдалтай байна.

3.2 Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, гүйцэтгэл:

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулиар ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 9,369.0 сая төгрөгөөр баталжээ.

Энэ нь өмнөх онтой харьцуулахад улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 3,302.4 сая төгрөгөөр өссөн байна.

ОНХС-гаас хуваарилагдаж ирсэн санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу аймагт 4,556.9, суманд 4,812.0 сая төгрөгийг тус тус хуваарилж аймгийн ИТХ-аар батлуулжээ.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн XII/21 дугаар хуралдаанаар ОНХС-гийн хөрөнгөөр өмнөх оноос шилжих 4 төсөл, арга хэмжээнд 628.1 сая, тайлант онд шинээр хэрэгжих 16 төсөл арга хэмжээнд 3,225.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Тайлант онд аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх баталсан төсөл арга хэмжээнд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн XIV/01 дүгээр хуралдаанаар тайлант онд шинээр хэрэгжих 3 төсөл арга хэмжээний тайлант онд санхүүжих дүнг 264.9 сая төгрөгөөр нэмж баталсан.
2. Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд өөрчлөлт орсонтой холбоотойгоор аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XIV/01 дүгээр тогтоолоор 63.0 сая төгрөгийн өртөгтэй 1 төсөл арга хэмжээг хасаж, 3 төсөл арга хэмжээний тайлант онд санхүүжүүлэх дүнг 176.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, шинээр 2 төсөл арга хэмжээнд 369.0 сая төгрөгийг зарцуулахаар тус тус өөрчилж баталсан байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр нийт 4,600.9 сая төгрөгийг нийт 21 төсөл арга хэмжээ баталснаас 5,552.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр гэрээ байгуулж гүйцэтгэлээр 14 төсөл арга хэмжээг бүрэн, 5 төсөл арга хэмжээ дутуу, 2 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй нийт 3,882.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 84 хувьтай байна.

3.3 Сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, гүйцэтгэл:

Сумдад ОНХС-аас нийт 4,812.0 сая төгрөгийг хуваарилснаас санхүүжилтийг бүрэн авч эх үүсвэрийг өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдлээс 2,072.8, бусад эх үүсвэрээр 563,9, нэмэгдүүлэн малын тоо толгойн албан татвараар 2,125.6 нийт 408 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээнд 9,214.6 сая төгрөгийг зарцуулахаар баталснаас гүйцэтгэлээр 305 төсөл арга хэмжээний 5,814.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 63 хувьтай байна.

Энэ нь зарим суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүйтэй холбоотой байна. /Хавсралт 7-оос харна уу/

Сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд дараах зөрчлүүд илэрсэн. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- Төсөл, арга хэмжээг гүйцэтгэсэн байгууллага ажлыг хүлээлгэж өгөөгүй, ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг олгосон /Бүрэгхангай сум 1, Тэшиг сум 1 ажлын 1.0 сая, Баяннуур сум 1 ажил, Хутаг-Өндөр сум 3 ажлын нийт 125.0 сая төгрөг, Сэлэнгэ сум 1 ажлын 6.0 сая төгрөг/
- ОНХС-гийн хөрөнгөөс байгууллагад өгөх өглөг 97.2 сая, хувь хүнд өгөх 5.0 сая төгрөгийн өглөг, хувь хүнээс авах 7.0 сая төгрөгийн авлагыг тус тус барагдуулаагүй /Бүрэгхангай сум/
- ТБОНАХБАҮХАТ хуулийн 8.5 дахь заалтыг зөрчин 55.0 сая төгрөг зарцуулсан /Хялганат тосгон/
- Булган сумын 2-р багийн гэрэлтүүлэг төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтын зардал 4.3 сая төгрөгийг гүйцэтгэгч "Өвөлжөөн булаг" ХХК-д шилжүүлсэн /Булган сум/
- Тайлант онд ОНХС-гийн тайланг аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар батлагдсан НБББББ-ын 4.6-д заасны дагуу тайлагнаагүй /Булган сум, Рашаант сум/

3.4 Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл:

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 дугаар хуралдаанаар байгаль, орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээнд өмнөх оноос шилжих 3 төсөл, арга хэмжээнд 341.8 сая төгрөг, тайлант онд шинээр хэрэгжих 49 төсөл арга хэмжээнд 5,279.8 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ.

Тайлант онд байгаль, орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээнд зарцуулахаар баталсан төсөл арга хэмжээнд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

1.Аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн XIV/01 дүгээр хуралдаанаар тайлант онд шинээр хэрэгжих 4 төсөл арга хэмжээний тайлант онд санхүүжих дүнг 807.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 110.0 сая төгрөгийн өртөгтэй 1 төсөл арга хэмжээг хасаж, шинээр нэмж 14 төсөл арга хэмжээнд 972.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан.

2.Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XIV/01 дүгээр тогтоолоор 2 төсөл арга хэмжээний тайлант онд санхүүжүүлэх дүнг 20.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 80.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг хасаж, шинээр 1 арга хэмжээнд 79.0 сая төгрөгийг тус тус өөрчилж баталсан байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 58 арга хэмжээнд нийт 6,768.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 84 хувь буюу 5,849.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд гарсан байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- *Тайлант онд аймгийн байгаль хамгаалах сангаас 6 төсөл арга хэмжээний 362.0 сая төгрөгийг зориулалт бус зардалд зарцуулсан*
- *Байгаль хамгаалах сангаас цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээд 5.0 сая төгрөгийг зарцуулсан анхан шатны баримтаар тулгахад 3.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 1.3 сая төгрөгийг аймгийн төсөв төвлөрүүлээгүй байна.*

Сумдын байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд гарсан байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- *БХС-гаас Зэд хантай бүтээлийн нуруу-Дархан цаазат газрын захиргаанд 4.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаагүй дотоод хяналт сул /Сэлэнгэ сум/*
- *Хог цэвэрлэгээнд 15.0 сая төгрөг баталсан боловч гүйцэтгэлээр 0.1 сая төгрөгийг илүү шилжүүлсэн /Сэлэнгэ сум/*
- *БХС-гийн хөрөнгөөр хийгдэх батлагдсан төсөл арга хэмжээний ажил хийгдээгүй, санхүүжилтийг үлдээдгээр тайлагнасан /Могод сум/*
